



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Г
эрх бүхий албан тушаалтныг томилохыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55.2, Компанийн тухай хуулийн 81.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Мөнхбат овогтой Энхболдыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг М.Энхболдод үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН